

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛД
ГАРСАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗАРТ
ДААЛГАСАН ЗААЛТ БҮХИЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023.07.07

Алтай хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хагас жилд гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын хэрэгжилтийг тодорхойлох, үр дүнд суурилсан үнэлгээ хийж, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэн ирүүлсэн тогтоолын биелэлтэд үндэслэн гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хагас жилд гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын биелэлтийн товчоог танилцуулбал:

Хяналтад авсан тогтоолын тоо	24
Бүрэн хэрэгжсэн /100 %/	11
Хэрэгжих шатанд /70 %/	6
Хэрэгжилт хангалтгүй /30 %/	1
Хэрэгжээгүй / 0 %/	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	6
БИЕЛЭЛТИЙН ДҮН /ХУВЬ/	86.1

“Хэрэгжилт хангалтгүй” 1 тогтоолын шалтгаан:

№	Огноо, дугаар	Тогтоолын товч утга	Шалтгаан, тайлбар
1	2023.05.29 Дугаар 20	1.Дарив сумын “Дарив Эрчим хүч” ААТҮГ, Эрдэнэ сумын “Эрдэнэ эрчим хүч” ААТҮГ-уудыг өмчлөгчийн эрх шилжсэн өдрөөр тасалбар болгон татан буулгасугай. 3.Татан буугдаж буй дээрх байгууллагын дуусгалтын балансыг гаргуулж, өр авлагыг барагдуулан дүгнэлтийн хамт 2023 оны 06 дугаар сард багтаан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд танилцуулж ажиллах	Тус тогтоолын дагуу орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудыг татан буулгах комисс 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хуралдсан бөгөөд тус үйлдвэрийн газрууд нь өр төлбөрийн үлдэгдэлтэй тул дуусгалтын балансыг гаргаж, дүнг тайлагнах боломжгүй хүлээгдэж байна.

ДУГНЭЛТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хагас жилд гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хагас жилд гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий 24 тогтоолын 11 нь 100 %, 6 нь 70 %, 1 нь 30 %, 6 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй үнэлэгдэж, 86.1 хувийн хэрэгжилттэй байна.

2.Нийт 11 тогтоол буюу 45.8 хувь нь бүрэн хэрэгжсэн, 6 тогтоол буюу 25.0 хувь нь хэрэгжих шатанд байна.

3.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа удаашралтай байгаагаас “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг татан буулгах тухай” 20 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.

4.Хугацааны төгсгөлд батлагдсан, хэрэгжүүлж эхлэх хугацаа хүлээгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас 6 тогтоолын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хагас жилд гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газарт:

1.“Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг татан буулгах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах;

2.“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” үнэлэгдсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Үнэ бууруулж дахин дуудлагын худалдаа зохион байгуулах тухай” 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах;


Хоёр. Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газарт:

1.“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” үнэлэгдсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын төрийн албан хаагчдыг орон

сууц авахад нэг удаагийн буцалтгүй дэмжлэг үзүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

**Нэг. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс,
Байгаль орчин аялал жуулчлалын газарт:**

1."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" үнэлэгдсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээ батлах тухай" 32 дугаар, "Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" 33 дугаар, "Байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг батлах тухай" 34 дүгээр, "Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 35 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах;



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС